



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/185

Алтай хот

**Гэрээнд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсэг, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 88 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны "Төлөвлөгөө баталж, эрх шилжүүлэх тухай" А/13, 2023 оны "Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж, төлөвлөгөө батлах тухай" А/130 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/8591, Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 1/5650 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Монгол Улсын 2023 оны төсөвт үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилт нь батлагдсан Тайшир сумын сургуулийн барилгын их засварын ажлын гэрээний дүн, ажил гүйцэтгэх хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, гүйцэтгэгчтэй нэмэлт гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т олгосугай.

3. Үнийн өсөлтийн нэмэгдэл санхүүжилтийн гүйцэтгэлийг хянаж, олгох асуудлыг зохих журмын дагуу шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (С.Амгалан), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

4. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ